

“АЛСЫН ХАРАА -2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

2024 .12.02-ны өдөр

Улаанбаатар хот

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)	Үнэлгээ
				Он	Түвшин			
Зорилт 1.4. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон нүүдлийн соёл иргэншил, Монголын түүх, хэл соёл, ёс заншил, шашин, гүн ухааны судалгаа хийж, нийтийн хүртээл болгон хэвшиж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ.								
1.4.6.	Монгол хүний ёс суртахууны хэм хэмжээний талаарх судалгааг өргөжүүлэн хүүхэд залуус, төрийн албан хаагч, хууль, хүчний байгууллагын ажилтны ёс суртахууны нарийвчилсан судалгааг хийнэ.		-	-	-	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажилласан байна.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023.05.04-ний өдрөөс хүчин төгөлдөр болсноор УБЕГ-ын даргын 2023 оны А/1713 дугаар тушаалаар “Ёс зүйн зөвлөл”-ийг “Ёс зүйн дэд хороо” болгон өөрчилсөн. Ёс зүйн дэд хороо 2024 онд ёс зүйн зөрчилтэй холбоотой 13 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэн, "Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төв"-д ирүүлсэн албан хаагчдын ёс зүйтэй холбогдолтой 15 гомдлын шийдвэрлэлтийг гишүүд хуваарийн дагуу шалган, шалгасан дүнг ёс зүйн дэд хорооны хурлаар хэлэлцүүлэв. Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын дагуу гишүүд 13 гомдлыг шалган, дүгнэлт гарган эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу 6 албан хаагчид уучлалт гуйх сахилгын шийтгэл ноогдуулсан байна. Ёс зүйн дэд хороонд 2024 онд ирүүлсэн гомдлыг судлан нэгтгэн дүгнэвэл албан хаагчдын хүнд	100%

							суртал, харилцаа хандлагатай холбоотой гомдол 90 хувь байна.	
Зорилт 7.4. Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.								
7.4.4.	Салбарын алба хаагчдын цалин, хөлсний нэмэгдлийг тухайн жилийн инфляцын өсөлт, өндөр хөгжилтэй орны ижил төрлийн байгууллагын түвшинд хүргэнэ.		-	-	-	Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу Төрийн захиргааны албан 1083 албан хаагчийн цалинг 10 хувиар, 11 дүгээр хавсралтын дагуу төрийн үйлчилгээний 180 албан хаагчийн цалинг 20 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Мөн Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтын дагуу *Сум (тосгон) + 40 хувиар, *Аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх + 20 хувиар (албан тушаалын үндсэн цалингийн) тус тус нэмэгдүүлэв. Мөн Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд: - Салбар зөвлөлийн 2024.01.08-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор төрийн захиргааны 38 албан хаагчид шинээр, 577 албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг ахиулсан. - Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2-т нийтийн тээврийн тогтмол үйлчилгээтэй хот суурин газарт ажиллаж байгаа энэ журмын 8.1-д зааснаас бусад төрийн албан хаагч нь ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зайлшгүй шаардлагатай бол нийтийн тээврийн унааны зардлын 50 хувийг байгууллагаас нь нөхөн олгоно, мөн журмын 8.4-т төрийн албан хаагчийн өдрийн	100%

							хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно гэж заасны дагуу УБЕГ-ын даргын 2024 оны А/164 тушаалаар хоол унааны нөхөх төлбөрийг шинэчлэн тогтоосон бөгөөд 2024.11.01-ний өдрөөс эхлэн олгож эхлээд байна. - УБЕГ-ын даргын 2024.11.12-ны Б/595 дугаар тушаалаар байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа гэрээт албан хаагчдын цалинг 20 хувиар нэмэгдүүлэн 2025.01.02-ны өдрөөс олгохоор шийдвэрлэсэн.	
7.4.9.	Иргэний үнэмлэх, гадаад паспортын бичилт хийх үйлдвэрийг өргөтгөж, бэлдэц үйлдвэрлэх дотоодын үйлдвэр байгуулна.	10313.0	-	2022	3742.6	Иргэний үнэмлэх, гадаад паспортын бичилт хийх үйлдвэрийг өргөтгөсөн байна.	Үндэсний энгийн гадаад паспортын бичилтийн үйлдвэрийн байрыг олон улсын стандартыг хангасан байдлаар засварлан тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулж 2022.10.01-ний өдрөөс ашиглалтад оруулсан. УБЕГ-ын даргын 2024 оны А/09 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо хуралдаж, Иргэний үнэмлэхийн бичилтийн үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай Иргэний үнэмлэхийн машин, дагалдах тоног төхөөрөмж, систем худалдан авах тендерийн урилгыг 2024.01.18-ны өдөр www.tender.gov.mn, www.burtgel.gov.mn сайтад тус тус байршуулж, “Смарт карт” ХХК-ийн тендерт шалгаран 2024/34 тоот гэрээ байгуулсан. Тухайн гэрээний дагуу нийлүүлсэн барааг УБЕГ-ын даргын 2024.04.09-ний өдрийн А/57 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн гишүүд акт үйлдэж, хүлээн авсан болно. Гэрээний гүйцэтгэл 100 хувь. Иргэний үнэмлэх бичилтийн үйлдвэрийн Datacard MX2100 хэвлэх төхөөрөмжид шинэ загварын NFC цахим үнэмлэхийн бэлдэц ашиглан хэрэглээнд нэвтрүүлэх тохиргоо, туршин тестлэх ажил хийгдэж дууссан бөгөөд 2024 онд 262,360 ширхэг NFC цахим үнэмлэхийг хэвлэгдсэн байна. Тайлант хугацаанд гадаад паспорт авах 811,216 иргэний (энгийн гадаад паспорт авах 152,264, цахим	100%

						гадаад паспорт авах 658,952) хүсэлтийг хүлээн авч олгосон байна. ТӨБЗГ-ын 2024.05.16-ны өдрийн 234 дүгээр тогтоолоор УБЕГ-ын хөрөнгөд бүртгэлтэй 43 нэр төрлийн 16.115,1 сая төгрөгийн үнэтэй хөрөнгийг “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨДХХК-ийн төрийн мэдлийн 51 хувьд тооцон хувь нийлүүлсэн хөрөнгө (дүрмийн сан)-д шилжүүлэх тогтоолын дагуу 2024.10.26-ны өдөр УБЕГ-ын дэргэдэх үндэсний энгийн гадаад паспортын бичилтийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, программ хангамж, улсын бүртгэлийн сүлжээг “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨДХХК-ийн тусгай зориулалт бүхий байранд нүүлгэн шилжүүлсэн.	
7.4.10	Бүртгэлийн байгууллагын мэдээллийн баазыг бэхжүүлэх, хадгалалтыг сайжруулах зорилгоор сүүлийн үеийн өндөр хүчин чадал бүхий сервер, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчилнэ.	680.0	-	-	678.8	Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн байна. Бүртгэлийн байгууллагын мэдээллийн баазыг бэхжүүлэх, хадгалалтыг сайжруулах зорилгоор дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1.УБЕГ-ын 2024 оны А/06 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо “Мэдээллийн технологийн үйлчилгээ” тендерийн баримт бичгийг боловсруулж урилгыг 2024.01.17-ны өдөр цахим системд нийтэлж нээлттэй тендер шалгаруулан “Саммит компьютер” ХХК-ийн шалгарч 2024.02.27-ны өдрийн 2024/11 дугаартай “Худалдах худалдан авах гэрээ”-г байгуулан тоног төхөөрөмж, лицензийн худалдан авалтыг хийсэн. Үүнд: • Dell All Flash Unity 380 серверийн хард диск 1 ширхэг, • Dell All Flash Unity 880 серверийн хард диск 1 ширхэг • Dell NX3230серверийн хард диск 6 ширхэг • Dell R740 серверийн хард диск 4 ширхгийг тус тус худалдан авч нөөц бүрдүүлсэн. Гэрээний гүйцэтгэл 100%. 2.Улсын бүртгэлийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай техник хэрэгсэл, техникийн үйлчилгээ, лиценз худалдан авах ажиллагааг явуулан “Саммит компьютер технологи” ХХК шалгарч “Улсын бүртгэлийн техник хэрэгсэл, техникийн үйлчилгээ, лиценз худалдан	100%

						авах тендер” 2024/22 тоот гэрээ байгуулж, тус гэрээний дагуу нийлүүлсэн барааг УБЕГ-ын даргын 2024.03.11-ний өдрийн А/36 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг хүлээн авсан. Гэрээний гүйцэтгэл 100%. 3.УБЕГ-ын тоног төхөөрөмж болох 3,750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барааны худалдан авалтын нээлттэй тендерийг 2024.01.18-ны өдөр зохион байгуулж “Смарт карт” ХХК шалгаран 2024/34 тоот гэрээ байгуулж, гэрээний дагуу иргэний үнэмлэх хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжийг УБЕГ-ын даргын 2024.04.09-ний өдрийн А/57 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг хүлээн авсан. Гэрээний гүйцэтгэл 100 хувь. 4.Серверийн өрөөний орчны аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хүрээнд агааржуулалтын систем /Air condition/, дизель генераторт үзлэг оношилгоо, засвар үйлчилгээ, цахилгаан тасарсан үед нөөц эх үүсвэрээр хангах зорилгоор “Саммит компьютер технологи” ХХК-аар генераторт сервис үйлчилгээг тус тус хийж 1 жилийн хугацаатай сервис үйлчилгээ хийх 2024/11 дугаартай гэрээ байгуулсан. Мөн тог баригчийн өрөөний агааржуулалт, хөргөлтийн системийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор Midea MAV008T1N2S Precision төрлийн air condition худалдан авч суурилуулсан.	
7.4.20	Улсын бүртгэлийн мэдээллийн сан газар зүйн өөр байршилд нөөц сантай болгоно.	-	-	-	Улсын бүртгэлийн цахим сангийн хэвийн ажиллагаа хангагдсан байна.	Үндэсний дата төвд Улсын бүртгэлийн мэдээллийн сан байршдаг ба Үндэсний дата төв нь нөөц төвийг Дархан-Уул аймагт байгуулсан. Тус нөөцийн төвд байрших Бүртгэлийн системийн нөөц төв байгуулахад нэн шаардлагатай тоног төхөөрөмж, лицензийн жагсаалт (ажлын даалгавар)-ыг боловсруулан “Ухаалаг засаг-2” төслийн нэгжид хүргүүлсэн бөгөөд зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар болон холбогдох баримт бичгийг ЦХХХЯ болон төсөл хэрэгжүүлэх нэгжид бэлтгэн хүргүүлсэн.	100%

							“Дэлхийн банк”-аас төсөл хариуцсан эрх бүхий албан тушаалтнууд 2024 оны 02 дугаар сард Монгол улсад айлчлан ирсэн бөгөөд төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, үе шаттай хэрэгжүүлэх, цаг хугацааг тодорхой болгох зорилгоор төслөөс үр шим хүртэгч байгууллагуудын удирдлагатай хийсэн нэгдсэн уулзалт болон техникийн 2 удаагийн уулзалтад манай байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд оролцож уг төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой санал бодлоо солилцсон.	
7.4.30	Хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэл, танилтын системийг нэвтрүүлнэ.	2400.0	-	2022	2398.8	Хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэл, танилтын системийг нэвтрүүлсэн байна.	Биеийн давхцахгүй өгөгдөл буюу AFIS программын албан ёсны эрхийг 2022 онд авч, 2023 онд диспачерийг шинэчилснээр биеийн давхцахгүй өгөгдлийн программыг бүрэн шинэчилсэн. Монгол Улсын 3 сая иргэний биометрийн мэдээллийг (10 хурууны хээний дүрснүүд, фото зураг) бүртгэх баталгаажуулах, таних, дамжуулах бүх боломжийг хангасан AFIS лицензийг хүлээн авч системд нэвтрүүлсэн. Биеийн давхцахгүй өгөгдөл (хурууны хээ)-ийг шинэ (виртуал) сервер рүү шилжүүлэн хэвийн аюулгүй байдлыг ханган ажилласан.	100%
Дундаж үнэлгээ								100% буюу 5 оноо

--oOo--